



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 35 (608)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц батлах тухай зарлигт өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай*
- *Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвтэл

2009 оны есдүгээр сарын 18 № 35 (608)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

473.	Шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 53	775
474.	Жи Хеун Тейкийг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 54	775
475.	Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц батлах тухай зарлиг өөрчлөлт оруулах тухай	Дугаар 55	776
476.	Зарим хүнийг медалиар шагнах тухай	Дугаар 58	777
477.	Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилдох тухай	Дугаар 60	777

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

478.	Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай	Дугаар 142	778
479.	Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай	Дугаар 143	779
480.	Дүрэм батлах тухай	Дугаар 144	782
481.	Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай	Дугаар 149	783
482.	Төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай	Дугаар 152	784

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

483.	Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 3 дугаар дэд бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 20	784
------	---------------------------------------------------------------------------------------------	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

ШҮҮГЧ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.1, 58.1.4 дэх заалтыг тус тус баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөрөө хүсэлт гаргасан тул Шагдаргомбын Төмөрбаатарыг Дундговь аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн, Төмөрбаатарын Оюунхандыг Архангай аймгийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн,

Далайн Эхабаатарыг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн, тэтгэвэр тогтоох насанд хүрсэн тул Сугарын Өлзийсайханыг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Базаргүрийн Нүрээдмааг Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгчийн, Балдангийн Загдхорлоог Дорнод аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

ЖИ ХЕУН ТЕЙКИЙГ "НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Монгол Улс, БНСУ-ын хоорондын эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, түүний дотор шүд, эрүү нүүр, эмгэг судлалын салбарын сургалт, үйлчилгээг боловсронгуй болгох, хөгжүүлэх, эмч нарын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэхэд оруулсан оюуны болон материаллаг тусламж, хоёр улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж

байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын шүдний мэргэжилтнүүдийн холбооны хүндэт гишүүн, БНСУ-ын иргэн, доктор, профессор Жи Хеун Тейкийг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ БАТЛАХ ТУХАЙ ЗАРЛИГТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн "Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц батлах тухай" 26 дугаар зарлигийн хавсралтын зарим зүйлд,

өөрчлөлт оруулж, хавсралтаар баталсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 26 дугаар зарлигийн хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 55 дугаар зарлигийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ

Д/д	Албан тушаал	Зэрэглэл	Бүтэц
1.	Тамгын газрын дарга бөгөөд Улс төр, цэргийн бодлого хариуцсан ахлах зөвлөх	ТӨ-V	1
2.	Ерөнхийлөгчийн зөвлөхүүд /Хуулийн бодлого, Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн бодлого, Гадаад харилцааны бодлого, Үндэсний аюулгүй байдлын бодлого, Хүний эрх, иргэний оролцооны бодлого, Төсөв, мөнгө, татварын бодлого, Олон нийтийн харилцаа, нийтлэг бодлого, Хот, хөдөөгийн хөгжлийн бодлого, Эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, технологийн бодлого, шашны асуудал, Байгаль орчин, амьдрах орчны бодлого, Хөгжлийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн бодлого/	ТӨ VIA	11
3.	Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч	ТӨ VIA	1
4.	Ерөнхийлөгчийн шадар туслах, туслах: /Ерөнхийлөгчийн шуурхай зохицуулалт хариуцсан шадар туслах, Ерөнхийлөгчийн судалгаа, орчуулгын асуудал хариуцсан шадар туслах, Ерөнхийлөгчийн хуулийн асуудал хариуцсан туслах/	AA-7	3
5.	Тамгын газрын дэд дарга	AA-1	2
6.	Албаны дарга	AA-2	3
7.	Ахлах референт	AA-5	1
8.	Референт	AA-6	19
9.	Ахлах шинжээч	AA-7	1
10.	Шинжээч	AA-7	1
11.	Бичиг хэргийн ахлах зааварлагч, редактор	AA-9	1
12.	Тамгын газрын даргын нарийн бичиг, туслах	AA-10	2
13.	Үйлчилгээний ажилтан: /Бичээч, гадаад хэлний бичээч, шагналын холбогдолтой архив, судалгааны ажилтан, техник болон программ хангамж хариуцсан ажилтан/	ТУ-4	4
	ДҮН		50

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Зарим хүнийг медалиар шагнах тухай

Үер ус, гал түймрийн аюулаас олон хүний амь нас, эд хөрөнгө авран хамгаалах ажиллагаанд эрэлхэг зориг, аехаалж самбаа, мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажилласан дор дурдсан хүмүүсийг медалиар шагнасугай.

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Гомбожавын Амарбаясгалан - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн ой, хээрийн түймэртэй тэмцэх нэгжийн шүхэрчин-гал сөнөөгч, дээд түрүүч
2. Батсүхийн Батбилэг - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн эрэн хайх аврах бүлгийн дарга, шадар дэслэгч
3. Жамсрангийн Баяртогтох - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн эрэн хайх, аврах нэгжийн аврагч, тэргүүн түрүүч
4. Мөнхбаатарын Бямбасүрэн - ОБЕГ-ын авто базын жолооч, дээд түрүүч
5. Бадамсамбуугийн Гансүх - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах отрядын бүлгийн дарга, шадар дэслэгч
6. Бямбажавын Гэрэлт-Од - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн ой хээрийн түймэртэй тэмцэх нэгжийн шүхэрчин-гал сөнөөгч, тэргүүн түрүүч

"ШУДАРГА ЖУРАМ" МЕДАЛИАР:

1. Алтантуяагийн Амгаланбаатар - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах отрядын аврагч, тэргүүн түрүүч
2. Бямбагэрэлийн Алтан-Эрдэнэ - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн эрэн хайх, аврах нэгжийн аврагч, шадар түрүүч
3. Дагвадоржийн Арсланбаатар - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны иргэн
4. Даржаагийн Батболд - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн эрэн хайх, аврах нэгжийн аврагч, тэргүүн түрүүч
5. Түмэжжаргалын Бат-Итгэл - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах, гал унтраах 11 дүгээр ангийн салааны захирагч, шадар дэслэгч
6. Бат-Өлзийн Баттулга - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах отрядын холбооны техникч, дээд түрүүч
7. Энхээгийн Баттулга - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах, гал унтраах 63 дугаар ангийн салааны захирагч, шадар дэслэгч
8. Банзрагчийн Батцэнгэл - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах отрядын аврагч-жолооч, дээд түрүүч
9. Борбаатарын Баярбат - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн эрэн хайх, аврах нэгжийн аврагч, шадар түрүүч
10. Ганхүүгийн Болдбаатар - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах, гал унтраах 63 дугаар ангийн гал сөнөөгч, тэргүүн түрүүч
11. Арьяажавын Бямбадорж - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах отрядын аврагч-жолооч, дээд түрүүч
12. Бяслугийн Ганболд - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны иргэн, "Магда" ХХК-ийн мужаан
13. Оюунчимэгийн Гансүх - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн эрэн хайх, аврах нэгжийн аврагч, тэргүүн түрүүч
14. Мөнххооны Гантоого - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн ой, хээрийн түймэртэй тэмцэх нэгжийн шүхэрчин-гал сөнөөгч, тэргүүн түрүүч
15. Самбуугийн Мөнгөншагай - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн эрэн хайх, аврах нэгжийн аврагч, шадар түрүүч
16. Цэцмидийн Отгон - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах, гал унтраах 30 дугаар ангийн гал сөнөөгч, дээд түрүүч
17. Дашдэндэвийн Туяа - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч
18. Халтарын Цогбадрах - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах отрядын аврагч, тэргүүн түрүүч
19. Элзэвийн Энхцог - Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах, гал унтраах 63 дугаар ангийн гал сөнөөгч, тэргүүн түрүүч

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.4, 32.6 дахь хэсгийг тус тус баримтлан Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Дансрангийн Баавууг Увс аймгийн шүүхийн

Ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн 2009 онд улсын хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил,

зориулалтыг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД Х.БАТТУЛГА

Засгийн газрын 2009 оны 142 дугаар тогтоолын хавсралт

2009 ОНД ИРГЭДЭД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН НИЙТ ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ

№	Аймаг, нийслэлийн нэр	Өмчлүүлэх газрын байршил	Иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ /га-гаар/	Өмчлүүлэх газрын зориулалт (га-гаар)							
				Иргэдэд үнэгүй өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Үүнээс			Аж. ахуйн зориулалтаар	Үүнээс		
					Одоо эзэмшиж байгаа газрын нийт хэмжээ	Шинээр өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Улсын чанартай автозамын дагуу өмчлүүлэх газрын нийт хэмжээ		Үр тарианы	Төмс, хүүсний ногооны	Газар тариалангийнхаас бусад
А	1	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Архангай	Аймаг, сумын төвд	1008,772	737,772	337,71	383,302	16,76	271	200	60	11
2	Баян-Өлгий	Аймаг, сумын төвд	591,36	542,36	331,86	210,5		49		47	2
3	Баянхонгор	Аймаг, сумын төвд	165,18	165,18	93,58	71,6					
4	Булган	Аймаг, сумын төвд	1610,18	901,54	319,41	582,13		708,64	660	48,64	
5	Говь-Алтай	Аймаг, сумын төвд	188,837	170,97	48,63	122,34		17,867		1,8	16,067
6	Говьсүмбэр	Аймаг, сумын төвд	122,75	122,75	8,9	113,85					
7	Дархан-Уул	Аймаг, сумын төвд	968,76	968,76	494,63	474,13					
8	Дорноговь	Аймаг, сумын төвд	150,746	150,746	17,275	133,471					
9	Дорнод	Аймаг, сумын төвд	463,9	463,9	85,8	378,1					



10	Дундговь	Аймаг, сумын төвд	218	218	122	96					
11	Завхан	Аймаг, сумын төвд	147,88	143,28	91,73	51,55	4,6	2	2,6		
12	Орхон	Аймаг, сумын төвд	33,44	33,44	24,05	9,39					
13	Өвөрхангай	Аймаг, сумын төвд	355,79	355,1	88,6	246,2	20,3	0,69	0,69		
14	Өмнөговь	Аймаг, сумын төвд	360,12	154,68	6,17	148,51	205,44	185,44	20		
15	Сүхбаатар	Аймаг, сумын төвд	122,22	103,47	46,72	56,75	18,75	17,18	1,57		
16	Сэлэнгэ	Аймаг, сумын төвд	25065,7	4716,9	623,37	3758,63	334,9	20348,8	18810,08	1525,21	13,51
17	Төв	Аймаг, сумын төвд	63340,4	2023,04	137,14	1188,6	697,3	61317,36	35962	25258,5	96,86
18	Увс	Аймаг, сумын төвд	283,26	193,26	87,06	106,2	90	90	90		
19	Ховд	Аймаг, сумын төвд	161,1	161,1	110,26	50,84					
20	Хөвсгөл	Аймаг, сумын төвд	218,86	218,86	215,15	3,71					
21	Хэнтий	Аймаг, сумын төвд	611,75	611,75	146,51	465,24					
22	Улаанбаатар	Нийслэлд	1387,92	1387,92	334,34	1053,58					
Улсын хэмжээнд			97576,925	14544,778	3770,895	9704,623	1069,26	83032,147	55632,08	27235,77	164,297

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай

Төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Засгийн газрын агентлагийн дарга болон Засаг дарга нартай байгуулах үйл ажиллагааны үр дүнгийн гэрээнд ил тод байдлыг илтгэх үзүүлэлтийг хангах талаар тусгаж, үнэлгээний гол шалгуур болгон дүгнэж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ДОЛГОР

Засгийн газрын 2009 оны 143 дугаар
тогтоолын хавсралт

ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур үзүүлэлт	Гарах үр дүн
Нэг, Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	
<p>1.1. Дараахь зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх:</p> <ul style="list-style-type: none"> -байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; -албан хаагчийн ёс зүйн дүрэм; -терийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь; -терийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт; -байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар. <p>1.2. Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p> <p>1.3. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p> <p>1.4. Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;</p> <p>1.5. Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинэжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх;</p> <p>1.6. Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p> <p>1.7. Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх.</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод болсон байна</p>
Хоёр, Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	
<p>2.1. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх;</p> <p>2.2. Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх;</p> <p>2.3. Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх;</p> <p>2.4. Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх;</p> <p>2.5. Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх;</p> <p>2.6. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх.</p>	<p>Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги, түүний хэрэгжилтийн явц, үр дүн нээлттэй, ил тод болсон байна</p>



Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал

3.1. Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх;

3.2. Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

3.3. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх;

3.4. Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;

3.5. Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх;

3.6. Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх;

3.7. Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх.

Байгууллагын төсөв боловсруулах, гүйцэтгэх, тайлагнах үйл явц нээлттэй, ил тод болсон байна

Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

4.1. Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх;

Байгууллагын худалдан авах ажиллагаа нээлттэй, ил тод болсон байна

4.2. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэргэслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/-т байршуулан, тогтмол шинэчилж байх;

4.3. Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол/-ийг оролцуулсан байх;

4.4. Тендэрт оролцохыг сонирхогчдоод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байх;

4.5. Тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх;

4.6. Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх;

4.7. Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх;

4.8. Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчид мэргэжлүүлсэн байх;

4.9. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх;

4.10. Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 20.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Жижиг, дунд үйлдвэрийн үндэсний зөвлөлийн дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Жижиг, дунд үйлдвэрийн үндэсний зөвлөлийн дүрмийг даган мөрдөж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж

ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Жижиг, дунд үйлдвэрийн Үндэсний зөвлөлийн дарга Т.Бадамжунайд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД Т.БАДАМЖУНАЙ**

Засгийн газрын 2009 оны 144 дүгээр тогтоолын хавсралт

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Жижиг, дунд үйлдвэрийн үндэсний зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

2. Зөвлөл нь Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль, төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар баримтлах бодлого, үндсэн чиглэл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эдийн засгийн салбаруудын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулахтай холбоотой санал, зөвлөмж гаргах үүрэгтэй.

3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

4. Зөвлөл нь гаргасан санал, зөвлөмжөө холбогдох яам, Засгийн газрын агентлагт хүргүүлэх ажлыг зохион байгуулж, жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж, хөтөлбөрийн биелэлтийн явц, үр дүнг тайланд тусган Засгийн газарт жил бүрийн эхний улиралд багтаан тайлагнана.

Хоёр. Зөвлөлийн зохион байгуулалт

5. Зөвлөл нь 15 хүртэл гишүүнтэй байх бөгөөд Зөвлөлийн гишүүнийг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 20.3-т заасны дагуу Ерөнхий сайд томилно.

6. Зөвлөлийн дарга нь үйлдвэр, худалдаа, үйлчилгээний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нарийн бичгийн дарга нь жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан Засгийн газрын агентлагийн дарга байна.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдааны журам

7. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

7.1. Зөвлөлийн хуралдаанаар дараахь асуудлыг хэлэлцэнэ:

7.1.1. жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, үндсэн

чиглэл, хөтөлбөрийн төсөл, тэдгээрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын асуудал;

7.1.2. жижиг, дунд үйлдвэрийн талаархи хууль тогтоомж болон хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай тайлан;

7.1.3. жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр улсын хэмжээнд болон бүс нутаг, аймаг, нийслэлд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, чиглэл;

7.1.4. жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр холбогдох яам, аймаг, нийслэлээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тайлан, мэдээлэл;

7.1.5. жижиг, дунд үйлдвэрт шинэ технологи нэвтрүүлэх, түүнийг нутагшуулах, үйлдвэрлэл, технологийн парк, инкубатор байгуулах үйл ажиллагааны чиглэл;

7.1.6. жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга зам, энэ чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, түүний үр ашгийг үнэлэх;

7.1.7. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны тайлан;

7.1.8. жижиг, дунд үйлдвэрт ажиллагсдын мэргэшлийг дээшлүүлэх, тухайн салбарт шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх асуудал;

7.1.9. жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээрх санал, төслүүд;

7.1.10. хууль тогтоомжид заасан бусад асуудал.

7.2. Зөвлөлийн хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлогч дарга, эсхүл гишүүдийн 30-аас дээш хувийн саналаар зарлан хуралдуулж болно.

7.3. Зөвлөлийн гишүүдийн олонхи ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

7.4. Зөвлөлийн хуралдааныг зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлогч дарга удирдан явуулна.

7.5. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга боловсруулж, ажлын гурваас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргүүлсэн байна.

7.6. Зөвлөлийн нарийн бичгийн дарга шаардлагатай тохилдолд хуралдаанаар хэлэлцэх асуудлаар тухайн салбарын эрдэмтэн, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, тодорхой санал, дүгнэлт гаргуулж болно.

7.7. Зөвлөлийн хуралдаанаас санал зөвлөмж гаргана. Хуралдааны явцын дэлгэрэнгүй тэмдэглэлийг албажуулах асуудлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.

7.8. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, хуралдаан даргалагч баталгаажуулна.

7.9. Зөвлөлийн хуралдаанаас гаргасан санал, зөвлөмжийг холбогдох яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

8. Зөвлөлийн хуралдааны чөлөө цагт зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга зөвлөлийн ажлыг зохион байгуулна.

9. Зөвлөлийн ажлын алба нь жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.

Дөрөв. Зөвлөлийн дарга, гишүүдийн эрх, үүрэг

10. Зөвлөлийн дарга дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

10.1. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

10.2. Зөвлөлийн хуралдааныг зарлах, удирдах.

11. Зөвлөлийн гишүүд дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

11.1. хариуцсан асуудлынхаа хүрээнд жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх асуудлыг хариуцах;

11.2. тухайн салбарт тулгамдаж байгаа асуудлыг боловсруулж, энэхүү дүрмийн дагуу зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх;

11.3. Зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжийг хариуцсан асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн талаар зөвлөлд тайлагнах.

12. Зөвлөлийн нарийн бичгийн дарга дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

12.1. Зөвлөлийн хуралдааны бэлтгэл хангах, гишүүдэд хуралдааны материал хүргүүлэх;

12.2. Хуралдааны тэмдэглэл хөтөлж албажуулах;

12.3. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, зөвлөлийн санал, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх, биелэлтийг шалгах, дүнг зөвлөлд мэдээлэх;

12.4. Зөвлөлийн нэр дээр ирсэн санал, хүсэлтэд хариу өгөх, дүнг зөвлөлд танилцуулах, зөвлөлийн даргаас өгсөн үүргийг зөвлөлийн гишүүд, холбогдох яам, байгууллага, албан тушаалтанд уламжилж, биелэлтийг гаргаж мэдээлэх;

12.5. Зөвлөлийн дотоод ажлыг эрхлэх.

Тав. Бусад асуудал

13. Зөвлөлийн дарга нь үйлдвэр, худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдгийг хэрэглэнэ.

14. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдгийг хэрэглэнэ.

15. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хариуцна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойг тохиолдуулан уг байлдаанд оролцсон амьд сэрүүн байгаа ахмад дайчин тус бүрт 500.000 (таван зуун мянган) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгохыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Батлан хамгаалахын сайд Л.Болд нарт даалгасугай.

2. Уг арга хэмжээнд шаардагдах 65.5 (жаран таван сая таван зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

Төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоол, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аялал жуулчлалын салбарын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий "Аялал жуулчлалын үндэсний төв" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулсугай.
2. "Аялал жуулчлалын үндэсний төв"

төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулагдсантай холбогдуулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Авто тээврийн газрын барилгын өргөтгөлийг тус үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Л.ГАНСҮХ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХУУЛИЙН 12 ДУГААР БҮЛГИЙН 3 ДУГААР ДЭД БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Гэр бүлийн хөрөнгийн эрхийг зохицуулсан Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 3 дугаар дэд бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Иргэний хуулийн (цаашид хуулийн гэх) 125 дугаар зүйлийн 125.1-д заасан "гэр бүлийн хөрөнгө" гэдэгт Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1., 3.1.3.-т зааснаар гэр бүл болсноо эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлсэн нөхөр, эхнэрийн, мөн зүйлийн 3.1.4., 3.1.5., 3.1.6.-д заасан гэрлэгчидтэй хамт амьдардаг гэрлэгчдийн төрсөн, үрчилсэн, дагавар хүүхэд, төрөл, садангийн хүмүүсийн хамтран өмчлөх дундын болон хуваарьт хөрөнгийг хамааруулан ойлгоно.

2. Хуулийн 126 дугаар зүйлийн 126.1-д заасан "гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд" гэдэгт Гэр бүлийн тухай хуульд зааснаар гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлснээс хойшхи хугацаа хамаарна.

Гэрлэгчид гэрлэлтээ үргэлжлүүлэх хүсэл зоригтой боловч хүндэтгэн үзэх тодорхой шалтгаанаар удаан хугацаагаар хамтран амьдрах боломжгүй байх нь (гадаадад ажиллах, цэргийн алба хаах, хорих ял эдлэх, удаан хугацаагаар эмчлүүлэх г.м.) энэ хугацаанд бий болсон хөрөнгийг гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмчлөлд тооцожгүй байх үндэслэл болохгүй.

3. Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийг зохицуулсан хуулийн 126 дугаар зүйлийн 126.2 дахь хэсгийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай.

3.1. Энэ зүйлийн 126.2.1-д заасан "хамтын хөдөлмөр" гэдэгт хуулийн этгээд байгуулахгүйгээр, өөрсдийн гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангах зорилготой, үүрэг оролцоог нь өөрсдөө хуваарилсан гэрлэгчид болон гэр бүлийн бусад гишүүдийн биеийн хүчний болон оюуны чиглэлийн үйл ажиллагааг ойлгоно.

"Аж ахуйн үйл ажиллагаа" гэж гэр бүлийн дундын хөрөнгө, гэрлэгчид болон гэр бүлийн бусад гишүүдийн хүч, хөдөлмөрт тулгуурласан, тэдний хэрэгцээг хангах зорилготой гэр бүлийн гишүүдийн эрхлэн явуулдаг үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа арилжааны ба оюуны чиглэлийн хамтын үйл ажиллагааг хэлнэ.

"Бусад орлого" гэдэгт энэ зүйлийн хамтын хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоос бусад буюу гэрлэгчид болон гэр бүлийн бусад гишүүдийн хөдөлмөр, үйл ажиллагааны, хуваарьт хөрөнгөд хамаарахаас бусад орлого, гэр бүлийн хэргэцээнд зориулж, бусдаас бэлэглэсэн эд хөрөнгө зэрэг хамаарна.

"Мөнгөн хуримтлал" гэдэгт гэрлэгчид болон гэр бүлийн гишүүдийн энэ зүйлд заасан хамтын хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон хийгээд бусад орлогоор бий болсон бэлэн ба хадгаламжид хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг ойлгоно.

"Шинээр бий болсон хөрөнгө" гэдэгт гэр бүлийн гишүүдийн хамтын хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, барьж байгуулсан барилга байгууламж, олсон орлого, мөнгөн хуримтлалаар худалдан авсан болон ажлын хөрс, урамшуулалд авсан үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийг хамааруулж үзнэ.

3.2. Мөн зүйлийн 126.2.2.-т заасан "гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийн орлогоор олж авсан үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө" гэдэгт гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг бусдад эзэмшүүлж, ашиглуулснаас олсон орлого, мөн дундын эзэмшлийн эрхийн шимтгэл, ногдол ашгийн орлого, зээлийн ба хадгаламжийн хүү, батлан даалт гаргасны төлбөр, өрийн бичиг, хууль буюу гэрээний дагуу авч байгаа хүү, анз, үл хөдлөх хийгээд хөдлөх хөрөнгө, үнэт цаас борлуулсны орлогоор бий болсон эд хөрөнгийг тус тус хамааруулан ойлгоно.

3.3. Энэ зүйлийн 126.2.3.-т заасан "ногдол хувь, үнэт цаас" нь гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгөд хамаарах орлогоор, гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон байхыг анхаарвал зохино.

3.4. Мөн зүйлийн 126.2.4.-т заасан "гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө" гэдэгт Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.-д зааснаар гэрлэгчтэй эрх бүхий байгууллагад бүртгүүлснээс хойшхи хугацаанд бий болсон, мөн зүйлийн 126.2.1.-126.2.3-т зааснаас бусад, хуулийн 127 дугаар зүйлийн 127.1.-д заасан хуваарьт хөрөнгөд хамаарахгүй, өмчлөх, эсхүл зөвхөн эзэмших, ашиглах эрх нь гэр бүлийн гишүүний хэн нэгний нэр дээр бүртгэгдсэн эд юмс, оюуны үнэт зүйлс, эрхийг хамааруулна.

3.5. Энэ зүйлийн 126.2.5.-д заасан "хуваарьт хөрөнгөөс дундаа хамтран өмчлөхөд зориулж шилжүүлсэн хөрөнгө, мөнгөн хуримтлал" гэдэг нь сайн дурын үндсэн дээр дундаа хамтран эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулахын тулд гэр бүлийн дундын өмчлөлд шилжүүлсэн, хуулийн 127 дугаар зүйлд заасан гэр бүлийн гишүүний хуваарьт өмчид хамаарах, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрх, мөнгөн хуримтлал байна. Ийнхүү шилжүүлсэн нь гэрээгээр тохиролцох, дундын дансанд шилжүүлэх, эрхийн улсын бүртгэлд болон дансны эзэмшигчийн нэрийн бүртгэлд өөрчлөлт оруулах, эдгээр ажиллагаанаас олсон орлогыг хамтын хэрэгцээнд хэрэглэх зэргээр илэрхийлэгдэнэ.

3.6. Мөн зүйлийн 126.3.-т зааснаар "анх гэр бүл болоход зориулагдсан" буюу Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлж, гэр бүл болсонтой холбоотойгоор, тухайн

гэр бүлийн хамтын амьдрал, ахуйн хэрэгцээг хангах зорилгоор өмчлөгдсөн, гэрлэгчдийн аль нэгний, эсхүл тэдгээрийн төрөл, садангийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг тухайн гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд тооцож болно.

4. Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгийн талаарх хуулийн 127 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг доорх байдлаар тайлбарласугай.

4.1. Энэ зүйлийн 127.1.1.-д заасан "эд хөрөнгийн эрх"-эд мөн хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5.-д зааснаар эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх хамаарах тул гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгөд гэрлэхээс өмнө олж авсан эдийн бус хөрөнгө болох эрх өөрөө, мөн түүнээс олох ашиг, орлого, үр шим г.м эд хөрөнгө багтана.

4.2. Мөн зүйлийн 127.1.2.-т заасан "бэлэглэлийн журмаар шилжүүлэн авсан мөнгөн хуримтлал, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх"-эд хуулийн 126 дугаар зүйлийн 126.3.-т заасан гэр бүл болоход нь зориулж бусдаас бэлэглэсэн мөнгөн хуримтлал, эд хөрөнгө, эрх үл хамаарна.

4.3. Энэ зүйлийн 127.1.3.-т заасан "амин хувийн хэрэгцээг хангахад зориулсан эд хөрөнгөд" гэрлэснээс хойш бий болсон үнэт эдлэл, эрдэнэсийн зүйлс зэрэг хамаарахгүй.

4.4. Мөн зүйлийн 127.1.4.-т заасан "оюуны өмчлөлийн зүйлийн үнэ" гэдэгт захиалга буюу гэрээгээр гүйцэтгэсэн ажлын хөрс, эсхүл уралдаанд шалгаруулалтын шагналыг ойлгоно. Зохиогчийн эрхийн бүтээл ашиглуулсаны хөрс, борлуулсны үнэ, хууль бус ашигласнаас учирсан хохирлын нөхөх олговор зэрэг нь энэ зүйлд заасан үнэ буюу зохиогчийн шагналд хамаарахгүй.

4.5. Энэ зүйлийн 127.1.6.-д заасан "мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад хамаарагдах хөрөнгө, мөнгө" гэж гэр бүлийн гишүүн өөрийн хуваарьт эд хөрөнгөөр бий болгосон, эзэмшсэн мэргэжил, эрхэлж буй ажилд нь шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл, ийнхүү ажил, хөдөлмөр эрхлэхэд нь зориулагдах мөнгөн хөрөнгийг хэлнэ.

4.6. Мөн зүйлийн 127.3.-т заасан "хувийн үйл ажиллагаатай холбогдсон үүрэг" гэдэгт гэр бүлийн гишүүний хувийн байдалтай салшгүй холбоотой, эсхүл гүйцэтгэл нь гагцхүү түүнд л хамааралтай үүргийг ойлговол зохино.

5. Гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх хуулийн 128 дугаар зүйлийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай.

5.1. Энэ зүйлийн 128.2.-т заасан "гэр бүлийн насанд хүрсэн гишүүний ... зөвшөөрлийг" зөвхөн уг гишүүн үл хөдлөх эд хөрөнгийн хамтран өмчлөгчөөр эрхийн бүртгэлд бүртгэгдсэн тохиолдолд авна.



Гэр бүлийн гишүүний хэн нэгний нэр дээр өмчлөх эрх бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийг гэр бүлийн дундын өмчлөлд бүртгүүлэхээр гэрлэгчид болон гэр бүлийн бусад гишүүд хуулийн 126 дугаар зүйлийн 126.2.4.-т зааснаар шаардах эрхтэй боловч ийнхүү эд хөрөнгийг захиран зарцуулах хэлцэл хийгдэх үед өмчлөгчөөр бүртгэгдээгүй байсан гэр бүлийн гишүүн хэлцлийн хүчин төгөлдөр байдлын талаар маргах эрхгүй болно.

5.2. Мөн зүйлийн 128.4.-т заасан **"олсон ашиг орлого"** гэдэгт хуулийн 126 дугаар зүйлд заасан гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийн орлого, хамтын хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлснээс олсон орлого, мөнгөн хуримтлал, шинээр бий болсон хөрөнгө, дундын хөрөнгийн орлогоор олж авсан үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, ногдол хувь, үнэт цаасны ашиг зэрэг хамаарна.

6. Гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлох хуулийн 129 дүгээр зүйлийн зарим заалтыг доорх байдлаар тайлбарласугай.

6.1. Энэ зүйлийн 129.1.1.-д заасан **"гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарах"** гэдэгт гэрлэлт цуцлах, гэрлэлтийг хүчингүйд тооцох, өрх тусгаарлах зэргээр тухайн гэр бүлээс албан ёсоор гарч, иргэний бүртгэлд өөрчлөлт орох тохиолдлуудыг хамааруулна.

6.2. Мөн зүйлийн 129.1.2.-т зааснаар **"гэрлэгчдээс төлбөр гаргуулахад тэдгээрийн хуваарьт эд хөрөнгө хүрэлцэхгүй бол"** гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс тэдгээрт ногдох хэсгийг тодорхойлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.7-д заасны дагуу төлбөр төлөгчийн эд хөрөнгийн ногдох хэсгээр төлбөрийг хариуцуулна.

6.3. Энэ зүйлийн 129.1.3.-т заасан **"гэр бүлийн бусад гишүүнээс төлбөр"** гаргуулахад тэдгээрийн хуваарьт хөрөнгө хүрэлцэхгүй бол мөн зүйлийн 129.1.2.-т заасантай адил зохицуулна.

6.4. Мөн зүйлийн 129.4.-т заасан **"гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бий болоход оруулсан түүний хөдөлмөрийн оролцоо, хөрөнгийн хэмжээг харгалзан үзэх"** үндэслэл нь гэрлэгчидээс бусад гэр бүлийн гишүүнд хамааралтай бөгөөд гэр бүлийн дундын өмчийг бий болгоход хөдөлмөр, хөрөнгөөрөө оролцсон гишүүд л тухайн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарах үед гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс ногдох

хэсгийг авах эрхтэй байна.

6.5. Гэрлэснээс хойш хүндэтгэн үзэх шалтгаанаар орлого олоогүй байсан эхнэр, нөхөр хөрөнгө хамтран өмчлөх эрхтэй болох талаар хуулийн 126 дугаар зүйлийн 126.4.-т заасан ба гэрлэлт цуцлах, гэрлэлтийг хүчингүйд тооцоход гэрлэгчид ногдох хөрөнгийг тодорхойлох журмыг хуулийн 129 дүгээр зүйлийн 129.3.-т заасан тул энэ зүйлийн 129.5.-д заасан **"гэр бүлийн гишүүн"** гэдэгт гэрлэгчидээс бусад гэр бүлийн гишүүн хамаарна.

6.6. Энэ зүйлийн 129.7.-д зааснаар гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гэр бүлийн гишүүдийн хамтран хүлээх үүргийн, эсхүл ашиг орлогыг нь гэр бүлийн хэрэгцээнд ашигласан гэр бүлийн гишүүдийн хэн нэгний хүлээх үүргийн төлбөрийг гаргуулах ба уг эд хөрөнгө хүрэлцэхгүй бол хамтран хариуцлага хүлээх гэр бүлийн гишүүн бүрийн, эсхүл үүрэг бүхий нэг гишүүний хуваарьт хөрөнгөөс гаргуулна. Төлбөр хариуцах уг зарчим нь хуулийн 127 дугаар зүйлийн 127.3., 129 дүгээр зүйлийн 129.1.2., 129.1.3.-т заасан төлбөрүүдэд хамааралгүй болно.

7. Хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан **"гэр бүлийн аж ахуйг цаашид явуулахад зайлшгүй шаардагдах хөрөнгө"** нь гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгөд хамаарах тухайн гэр бүлийн амьжиргааг залгуулж, хэвийн амьдрах нөхцөлийг бүрдүүлдэг ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, мал, тээврийн хэрэгсэл зэрэг эд хөрөнгө байна.

8. Мөн зүйлийн 131.2.-т заасан **"ногдох хэсгийг эд хөрөнгөөг өгөх боломжгүй"** гэдгийг гэр бүлийн аж ахуйг цаашид явуулахад зайлшгүй шаардагдах хөрөнгийг өгөх боломжгүй нөхцөл байдлаас гадна тухайн эд хөрөнгийн салгаж үл болох, нэгдмэл шинж чанартай хамааруулан ойлгож хэрэглэнэ.

9. Хуулийн 132 дугаар зүйлийн 132.2.-т заасан **"гэрлэгчид хөрөнгийн эрхийн гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлэх"** гэсэн шаардлага нь зөвхөн энэ зүйлийн 132.1-д заасан гэрээнд хамаарна.

Гэрлэгчид эд хөрөнгийн эрхтэй холбогдох бусад гэрээ, хэлцлийг хуульд заасан журам, хэлбэрээр хийнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

А.ДОРЖГОТОВ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргах.

Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын

Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12

Төрийн ордон-128 тоот

и-мэйл: turin_medeel@parliament.mn



262420, 329612

Индекс 14003



329487

Хэвлэлийн хуудас 1.5